



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2021.03.15 № 06

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангах зорилтын хүрээнд уг хөтөлбөрийн 3.5.1.2-т “Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлж, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина” хэмээн тусгасан билээ.

Та Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хувиар Засгийн газрын гишүүдийг томилсонтой холбогдуулан үндсэн дөрвөн зорилтоо танилцуулж хэлсэн үгэндээ эрчим хүчний нийт хэрэглээнийхээ 25 хувийг гаднаас авч, үүнд жилд дунджаар 140 сая ам.доллар зарцуулж буй өнөөгийн байдлыг халахын тулд “Тавантолгойн цахилгаан станц, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийг яаралтай дуусган, V цахилгааны станцын ажлыг эхлүүлэх болно” хэмээн мэдэгдсэн.

Үүнтэй холбоотойгоор 2021 оны хавар Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын гүйцэтгэгчийг тодруулж бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр болоод байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1–т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Танд хандан тавьж байна. Үүнд;

1.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын гүйцэтгэгчийг тодруулах ажлын явц болон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг 2021 оны хэддүгээр сард эхлүүлж, хэдэн онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа талаар;

2.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг хийх явцад болон бүрэн ашиглалтад орсны дараа байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, судалгааны тайланг олон нийтэд нээлттэй ил тод

2020000111


танилцуулах, нөлөөллийн бүсэд орж буй зарим айл өрх, иргэдэд нөхөн олговор олгох чиглэлээр Засгийн газар болон холбогдох байгууллага хэрхэн анхаарч байгаа талаар;

3.Усны тухай хуульд заасан эрчим хүчний зориулалтаар ус ашиглах талаар тусгасан зарим зохицуулалтыг илүү сайжруулах, ус ашигласны төлбөрийг одоо байгаа 2 хувиас нэмэгдүүлэх, Усан цахилгаан станц байгуулагдах сум, аймгийн иргэд, аж ахуйн нэгжийн эрчим хүчний үнэ тарифыг хямдруулах буюу үндсэн өртгөөр нь тооцон дэмжлэг үзүүлэх, эрх зүйн орчин бүрдүүлэх ямар боломжтой талаар тодорхой хариултыг ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасны дагуу ирүүлж, чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ

2020000111